



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/177

Есөнбулаг

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 71 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн орон нутгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх Цогт сумын төвд баригдах 0,8 км хатуу хучилттай авто замын ажлыг гүйцэтгэх эрхийг Цогт сумын Засаг дарга (Л.Насанбуян)-д шилжүүлсүгэй.

2.Төсөл арга хэмжээний ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг боловсруулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнахыг Цогт сумын Засаг дарга (Л.Насанбуян)-д үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2024 оны 01 дүгээр сарын А/98 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

